

Шамбалын орон, Шамбалын дайн
(Монголчуудын сэтгэлгээний шамбалын комплексийн
түүхийн товчоо)

Лувсандорж Ж.
/Карлын их сургууль/

Буддизмийг цус урсгадаггүй, дайн явуулдаггүй ганц шашин гэсэн талархах бодол нэлээд дэлгэрсэн юм. Энэ мөрүүдийг бичигч, ийм бодолтой дайралдах тохиолд сэтгэлд таатай, таагүй хоёр бодол зэрэгцдэг байсан. Таатай нь юу вэ гэвэл миний эцэг эхийн шашиныг сайнаар хэлсэн болохоор тэр. Юу нь таагүй вэ гэвэл буддизмийн нэг гол салбар болох ламаизмын түүхэнд болж өнгөрсөн цуст дайнчуудын түүх санагддаг байсан. Тэдгээр дайнчуудыг түүхч нар мэддэггүй биш, мэддэг ч, бичдэг ч байсан. Тэгэхдээ уг дайнчуудын гол шалтгааныг тухайн үед Хятад улсын эзэн болоод байсан Манж хааны улс төрийн бодлоготой холбож өнгөний үнэнийг тодорхойлдог боловч Төвөд ба Монголын ламын шашны улс төрийн бодлогыг тойрон өнгөрдөг болохоор гүний үнэнд нь нэвтэрч чаддаггүй юм. Үнэнд дуртай хүмүүс үнэний нь мэдэхийг хүсэж байна.

Тэдгээр дайнчуудын үнэн учрыг ойлгохын тулд дайны хөдөлгөгч хүч, уриа дуудлага болсон уг шашинтны сэтгэх арга – домгийн сэтгэлгээ рүү орох хэрэгтэй. Тийм учир энд эхлээд Шамбалын орон, Шамбалын дайн гэдэг юмны тухай ярих нь чухалтай болно.

Шамбалын¹ орон

Буддизмын сударт бичсэнээр бол бурхан Будда-г амьд сэрүүн байхад энэтхэгийн хойгоос умар зүгт орших Шамбалын орны Сучандра тэргүүтэй 97 хаан ид шидийн хүчээр нисч ирээд Будда бурхнаас ном номлож өгөхийг гуйсан. Будда тэдэнд Калачакрагийн (Цагийн хүрдэний номлол, Дүйнхор) номлолыг сургасан. Сучандра хаан

¹ Шамбал – санскрит хэлний S'ambhala (жаргалангийн эх булаг "source of happiness") гэдэг үгнээс ирэлтэй. Ламын шашинт монгол сүсэгтний итгэдэгээр бол манай дэлхий дээр байгаа буддийн шашинтны диваажингийн орон, буддийн судлалч эрдэмтний үздэгээр бол "name of the Buddhist Utopia, probably the capital of the eastern Greeks, i.e., of Bactria, where Buddhism of the Mahayana School in the first century before and first century after Christ flourished" (Sarat Chandra Das, Tibetan-English Dictionary, Delhi, 1970, p. 1231)

нутагтаа очоод тэр номлолыг бичиж үлдээсэн. Тэрнээс олон зуун жилийн дараа энэтхэгийн нэг бандида Шамбалын оронд хүрч тэрнийг цээжилж аваад буцсан. Ингэж буддизм Калачакра судартай болсон. Калачакра бол одон орон, тэнгэрийн зурхай, макро болон микро ертөнцийн нэгдмэл зүй тогтол, гараг однуудын явдал, ертөнц дэлхийн үүслийн домог, календарь зохиох арга, буддизм ба мусулман шашинтны хоорондын тэмцмэл, шашнуудын ирээдүйн тухай зөгнөл зэрэг олон чухал юмны тухай номлосон тантризмын номлол юм.²

Шамбал хаана байдаг вэ? Судруудад бичсэнээр бол: “энэтхэгээс умар зүгт цаст Келаша уулын баруунтаа Шамбал гэж жаргалтай сайхан орон байдаг. Нийслэл нь Калава хэмээх эрдэнэсээр бүтсэн хот байдаг. Хүмүүс нь бие хаа тэгш, маш гоо үзэсгэлэнтэй, ухаан төгс, оньсон аргад мэргэжсэн, жаахан ч муу санаагүй, өвчин зовлонгүй, сэтгэл амар, их жаргалтай амьдарч зуу насалдаг. Тэнд тариа будаа, ногоо жимс өөрөө ургана. Хоол унд хувцас хунар, эдлэл хэрэглэл маш элбэг... Ирээдүйд Шамбалын дайн болсны дараа тэр орны хаан Ригдэндагва³ арван хоёр тивийг (манай дэлхий) бүрэн эрхшээж тэр жаргалт амьдрал дэлхий дахинд дэлгэрнэ. Цааш Ригдэндагвын үр сад нар хаан суусаар 1650 жил болоод цагийн эрхээр шашин далдлахын ёсыг үзүүлнэ (шашин мөхнө)“.⁴

Буддийн шашинтаны идеал болсон тэр Шамбалын орон хаана байгааг олох гэж өрнөд ба дорнодын олон эрдэмтэн оролдсон. Тэдгээрээс хамгийн чухал, бодот үнэнд тун ойр хариу өгсөн судалгаа бол монголын эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн ажил байна. Түүний бичсэн нь “Шамбал бол Замбутивд⁵ байгаа Буддийн шашны таван ариун орны нэг юм. Замбутивийн төвд нь Ваджрасана, дорнод нь Утай, өмнөд нь Бодалан, өрнөд нь Удаяана энэ дөрөв нь бодтой байгаа тул тавдугаар умар зүгийн Шамбал нь бодтой байсан байх ёстой. Урьд тийм Шамбал гэж бодтой орон байсан боловч түүнийг лалын шашинтан устгасан. Жинхэнэ Шамбал бол энэтхэгийн хойно Гандхар буюу одоогийн Афганистан хавьд эрт цагт тэнд Буддийн шашин дэлгэрч байх үед байсан бололтой. Энэ Шамбал устсаны дараа Буддийн шашин дэлгэрч байсан одоогийн Дундад Азид тэр Шамбал бий гэж энэтхэгийн буддийн шашинтан боддог байсан. 1837 онд “Болор толь” гэдэг түүхийг бичсэн монгол Жамбадорж одоогийн Стамбул хотыг Шамбал мөн гэж боддог байсан.

10-р зууны үед Цилуба бандида Энэтхэгээс Шамбалыг эрж худалдаачидтай хамт их далайг туулж яваад Шамбалын оронд хүрч Калачакра номлолыг олж ирсэн⁶ гэдэг.

² Ц.Дамдинсүрэн, *Тантраража хэмээх номын доторхи хэдэн үгийн тухай тайлбар*, Хэл зохиол судлал, Улаанбаатар, 1980, тал 94

³ Монгол хэлээр Догшин хүрдэт хаан

⁴ Банчен богд Лувсанбалдандамбийнямчоглойнамжил, *Шамбалд зорчихуй* (Journey to S'ambhala, by Panchen Paldan Yeshe of Tashi-Ihunpo) Улаанбаатар, 2001, тал 7-8,13

⁵ Замбутив – санскрит хэлний j'ambudv'ipa (замбу модны тив) гэдэг үгнээс ирэлтэй. Манай дэлхийн ламаист нэр, Ц.Дамдинсүрэн, дурдсан зохиол, тал 97.

⁶ Будда бурханыг манай ертөнц дээр заларч байхад хүний орнуудаас төдийгүй тэнгэр, лусын орнуудаас эрдэмтэн хаад нь ирж бурханы номыг сонсоод авч одсоныг хожим энэтхэгийн эрдэмтэн тэнд очиж суралцаад буцааж авчирсан тухай домог нэг биш байдаг. Буддийн гүн ухааны сэтгэхүйн эх болсон Параджняпарамита номлолыг Нагарджуна багш лусын орноос (усны эзэдийн орон буюу далайн цаадхи орон бололтой) очиж авчирсан гэх.

Цилуба бандида бол одоогийн Стамбул буюу Сири хоёр орны аль нэгэнд очсон бололтой. Стамбул гэдэг үг Шамбал гэсэн нэртэй төстэй сонсогдоно. Сири орныг арабууд хойт зүгийн Шам гэж нэрлэдэг. Тэгэхлээр Цилуба бандида Сири орныг Шамбал гэж ойлгосон байж болох юм. Шамбалын домогийн дотор Мекка, Багдад зэрэг хотын нэр гарч байх нь умар зүгийн Шамбалын тухай энэтхэг домог ба умар зүгийн Шам (Сири) орны тухай араб домог хутгалдсан бололтой. Шамбалын орны нийслэл Калаба хот нь Сири орны хуучин нислэл Халеб хот ч байж магадгүй⁷.

Өрнөдийн судлагчид Шамбалыг буддийн шашинтны утопи гэдэг. Харин буддийн шашинтны хувьд бол тэр утопи биш, манай дэлхий дээр бодтой байгаа буддийн шашны ариун орон, хэрэв тэр орны ариун шашины эсрэг дайн гарвал тэр шамбалын цэрэг болох, хойт насандаа тэр оронд хүн болж төрөх нь сүсэгтний туйлын хүслэн юм.

Шамбалын дайн

Монголын түүхч Жамбадоржийн “Болор толь” (1837) гэдэг зохиолд: “Ирээдүйд 23 дугаар жараны улаагчин тахиа жилд (европын 2377 он) Сита мөрөний зах (цаана) Мака (Мекка) орны Багдад хотын тэрсүүдийн их хаан, Асурийн (демон) хувилгаан Жайвилодой гэгч өөрийн доорхи бага хаадтайгаа хамтран олон амьтныг алж их нүгэлт үйлийг үйлдээд Сита мөрөний өмнөх газар ба цаст Төвөд болон Замбутивийн хагас хиртэйг эзлэн аваад цааш ариун Шамбалын оронд довтлохыг завдана. Тэр цагт Шамбалын орны Догшин хүрдэт (Ригдэндагва) хаан, тэрсүүдийг дарах цаг ирснийг зарлаад ариун дайнд орно. Түүний цэрэг зэвсэг: дөрвөн зуун мянган согтуу заан хөлөглөсөн заант цэрэгийн тоо олон зуун мянга, явган цэргийн тоо цаглашгүй, салхин жигүүрт чулуун морь хөлөглөсөн алтан хүрдэт тэрэгнүүд, цахилгаан морьт цэргүүд, огторгуйгаас тавих чөдөр чулуун оньст хүрднүүд... Тэр их дайнд цагаан зүгийн Тэнгэр нар⁸ шамбалын талд, хар зүгийн Тэнгэр нар тэрсүүдийн талд орж байлдана. Догшин хүрдэт хаан Жайвилодойг, хүн нь хүнийг, морь нь морийг алж асар олон тэрсүүдийг үнсэн товрог болгоно. Тэгээд энэ Замбутив төдийгүй бусад тивүүдэд Шамбалын цэрэг орж буруу номтоныг алаад буддийн шашныг нар мэт мандуулах” гэж бичсэн юм.

Монголчууд Шамбалыг нээсэн нь

Шамбал, шамбалын дайны тухай эдгээр бичвэрүүд буддизмийн домог боловч сүсэгтний хувьд бол энэ домог биш, бурханы сударт бичээстэй бурханы үнэн үг болно. Сүсэгтэний дотор, ялангуяа домгийн сэтгэлгээтэй монгол түмний дунд энэ домог улам өргөжин хөгжиж энгийн, бодтой итгэл үнэмшил болж тэдний сэтгэлд бат суугдсан юм.

Шамбалын орон хаана байгаа, тэр тэрсүүд гэгч хэн болохыг эрдэмтэн судлагчид төдийгүй сүсэгтэнүүд эрж байсан. Эрдэмтэд олоогүй бол сүсэгтнүүд олсон. Тэд түүнийг сүсгийн хүчээр олсон юм. Тэдний нээсэн аксиом: *Шамбал гэдэг бол амьд бурхадын орон. Ламын шашины амьд бурхад бол шашины дээд богд, хутагт багш нар*

⁷ Ц.Дамдинсүрэн, дурдсан зохиол, тал 99-100.

⁸ Тэнгэр – Монголын бөөгийн сурталд цагаан зүгийн (амгалан) 55 Тэнгэр, хар зүгийн (догшин) 44 Тэнгэр, тэдний дунд төв үзэлт цэгээн Тэнгэр байдаг гэх.

(Гарма багш, Банчен эрдэни, Далай лам нар) ⁹ мөн. Тэгэхлээр тэдний залран байгаа цастан Товод, эрдэнийн их Лхаса хийд бол Шамбалын орон яагаад биш байх билээ.

Тэр тэрсүүд буюу буруу номтон гэдэг бол зовхон мусулман, боо, бонбо ¹⁰ тодийгүй ламын шашныг хагалан эвдэгч сорог урсгал бас мөн.

Бурханы шашныг гаднаас хэн ч эвдэхгүй, бурханы шавь нар өөр дотроосоо эвдэнэ гэсэн Будда багшийн айлдвар тун учиртай байнам. Яг чухмыг хэлбэл манай ламын шашиныг мусулмантан ч биш, харин сөрөг урсгалынхан бодтой заналхийлж байдаг биш үү! Тэгэхлээр тэрсүүдтэй дайн хийж өөрийнхөө багшийн шашныг аврах нь шамбалын ариун дайн байж таарна. Ийнхүү сүсэгтэн монголчуудын хувьд цаст Төвөд шамбалчилагдах нь тэр.

Сүсэгтнийхээ бодлыг сайн мэддэг лам багш нар бас чухал зүйлийг оллоо. IV Банчен-эрдэни (1570-1662), Бенса Лувсандондов гэдэг ламд залбирал бичихдээ, түүнийг ирээдүйд Шамбалын оронд Ригдэндагва нэртэй хаан нь болж төрнө гэж бичив. Удалгүй тэр Банчен-эрдэнийн шавь нар нь багшийгаа өнөөх Бенса Лувсандондовын хойт дүр мөн гэж зарлав. ¹¹ Ингээд Банчен-эрдэни ирээдүйд Шамбалын орны хаан болох боломжтой болчих нь тэр. Хожим нь VII Банчен-эрдэни (1782-1853): “эрт цагт би Шамбалын оронд Ригдэнжамбалдагва хэмээн нэрийдэж алтан ширээнд нэгэн зуун жил хаан сууж Калачакра номыг дэлгэрүүлэн суувай. Ирээдүй цагт би мөн тэр ширээнд хорин тавдугаар Ригдэндагва-хорлоен хэмээх нэрт хаан болон сууна” гэж бичжээ. ¹² Ингээд төвөд монголын сүсэгтэн олон түмэн, Банчен-эрдэнийг Шамбалын хаан байсан, одоо Товодод шамбалын ариун номын ёсыг үйлдэж байна, ирээдүйд шамбалын их дайныг удирдана гэж баттай итгэлээ.

Шамбалын дайны домог улам энгийн ойлгомжтой болсоор байлаа. Тэрс буруу сургаалтаны эсрэг явуулах шамбалын дайнд оролцсон хүн байтугай тэр дайны хөлд гишгэгдэн үхсэн өт хорхой ч гэсэн Шамбал диваажингийн оронд төрнө, тэгэхлээр шамбалын дайнд оролцвол хүн болсны хэрэг бүтэх нь тэр гэж бүрэн итгэцгээлээ. Монголчуудын “маань хөгжөөх” гэдэг нийтийн залбиралын дуунд “... Богд Банчен, Далай ламыгаа жсан (умар зүгийн) Шамбал гандан диваажингийн оронд дагалдан торье, ум-ма-ни-бад-ме-хум” гэж дуулдаг боллоо. Одоо ч дуулсаар байна.

Монголын академич Ц.Дамдинсүрэн “Шамбалын домог бол энэтхэг, төвөд, монгол ард түмний сайхан зөгнөл, бадрангуй мөрөөдөл, уран дүрслэлийн үр боловсрол

⁹ -Гарма багш – Ламаизмын гармапа урсгалын нэг гол салбарын номын багш, хоёрдугаар дүрийн Гармапа-г (1204-1283) Монголд урьж авчирснаас эхлэн монголчууд төвөдийн ламаизмыг Гарма багшийн шашин гэх болсон юм.

-Банчен-эрдэни – Ламаизмын гелүгпа (шарын шашин) сектийг үндэслэгч Зунхавын (Цонкапа) шавь эрдэмтэн лам Хайдавжи-г (1385-1438) хожим анхдугаар дүрийн Панчен лама гэж нэхэн өргөмжилсөн нь одоо хүртэл 10 дүр тодров. Монголчууд түүнийг шарын шашны багш төдийгүй Төвөдийн ерөнхийлөгчөөр үзэж өргөн хүндлэх нь Далай ламаас дутуугүй.

-Далай лам – Зунхавын шавь Гэндүндүб-ийг (1391-1474) анхдугаар дүрийн Далай ламаар нэхэн өргөмжилснөөс одоо хүртэл 14 дүр тодров.

¹⁰ бонбо – ламаизмын сударт 1) Төвөдийн эртний “бон” шашны нэр, 2) хятадын даосизм.

¹¹ Ц. Дамдинсүрэн, дурдсан зохиол, тал 99.

¹² Банчен богд, дурдсан зохиол, тал 7.

мөн болно. Энэ дэлхий дээр жаргалт сайхан амьдралыг байгуулж болно гэсэн энэ гол санаа нь биднийг Шамбалын домгийг онцлон судлах ёстой болгож байна” гэж бичсэн¹³ нь энгийн үг биш билээ.

Шамбалын домог тийнхүү түгээмэл дэлгэрч ард түмний сэтгэлийг эзэмдсэн болохоор лам багшийнхаа шашны эсрэг хүчинтэй амь хайргүй байлдан тэмцэж ирээдүй хойч үеийнхэндээ жаргалт амьдралыг олгохын төлөөнөө бадрангуй сэтгэлийн нэг тэнгэрлэг комплекс (шамбалаар өвчлөх буюу шамбалын комплекс) болж хэдэн зууны турш боловсорсон юм. Тийм болохоор Монголд ламаизм өвч дэлгэрсэн сүүлийн 400 жилийн дотор монгол, төвөдөд болж өнгөрсөн томхон дайнуудын учир шалтгааныг энэхүү шамбалын комплекстэй холбож үзвэл зөв үнэлэлт дүгнэлт хийх боломж нээгдэх буй заа.

1921 оны ардын хувьсгалын үед Монголд гарсан “Улаан туг” гэдэг цэргийн марш дууны дотор “*Шар тугийг мандуулаад шашныхаа сүрийг бадруулаад Шамбалын дайндаа мордоцгооно*”¹⁴ гэсэн бадаг байлаа.

Шамбалын комплект автсан олон нийтийг дайнд дуудах уриаг хувьсгалч¹⁵ нар ямар амархан олж чадсаныг эндээс харж болно.

Хувьсгалч нар удалгүй большевикжиж шашныг устгах бодлого барьж эхлэхэд ламын шашнаа хамгаалсан лам ба ардын зэвсэгт бослого дэгдлээ (1932). Уг бослогыг сүсэгтэн ард нийтээр шууд л шамбалын дайнд тооцож, Банчен-эрдэнид нууц элч явуулан түүний аврал тусламжийг “олж” байлаа. Уг дайныг эхлэх сайн сар өдөр, бослогыг удирдах хүний нэр, нас, төрсөн жилийг Банчен-эрдэниэс асуух, ялалтын шидэт тусламж ирүүлэхийг түүнээс хүсэж байсан билээ. Гэвч харамсалтай нь тэр үед хувьсгалт засаг, улсын хилийг хаасан байлаа. Гэсэн үүгээр товч оршлыг дуусган, Монгол, Төвөдөд болж өнгөрсөн Шамбалын дайнуудыг танилцуулах гол юмандаа орё.

Уг нь бүх шашин аллага ба дайныг жигшдэг. Гэтэл бүх шашинтан улс, өөрийн шашин суртлыг хамгаалах “ариун” дайнуудыг хийсээр ирсэн билээ. Буддизмийг судалсан европ эрдэмтдийн дотор “эртний амьд энэтхэг” гэгдсэн Төвөд, Монголд ч тийм дайнууд болдгоороо болоод өнгөрсөн юм. Тэдгээр дайнуудыг Төвөдийн Ламын шашны дээд удирдлага-Банчен Эрдэни, Далай Лам нарын хүсэлт, маш нууц зохион байгуулалтаар тэдний монгол шавь нар монгол нутагт өөр хоорондоо болон Төвдөд хийсэн. Тэр цуст дайнуудын суга таяг тулж хөл дээрээ зогссон төвөд-монголын ламын шашин (тодорхой хэлбэл Шарын шашин) одоо болоход цуст дайн хийдэггүй сайн шашин гэгдэх боллоо.

¹³ Ц.Дамдинсүрэн, дурдсан зохиол, тал 98.

¹⁴ Энэ дууны эхний хувилбарыг бүр Богд хаант Монгол улсын цэргүүд бас дуулж байсан бололтой. Үз: Luboš Bilka, *Mýtus o Šambhale a jeho burjatská aktualizace ve 20. století*, Revue pro religionistiku, ročník 10., 1/ 2002, Brno, str. 19.

¹⁵ Монгол Ардын Намын удирдагчид ба хувьсгалч нар өөрсдөө ч шамбалын комплекстөнгүүд байсан. Тэдний гол уриа нь “шашин төрөө мандуулах явдал” байв. Монголд “бугшиж” байсан Оросын цагаан гвардынханыг устгахад большевик засгаас цэргийн тусламж авч тэдэнтэй бат холбогдсоны учраар Монголын нам засаг тун удалгүй большевикуудын гар хөл болон хувирсан юм.

Шарын шашны лам түүхч нар тэдгээр дайнуудын түүхийн баримтуудыг өөрийн шашны үзэл суртлын үүднээс балласан, гуйвуулсан, бүрхэгдүүлсэн болохоор хожмын түүхч, судлагчид тухайн үеийн нийгмийн түүх, улс төрийн бодлоготой холбон, тэдний дайнуудыг газар нутаг булаалдсан дайн, бусдыг эзлэн түрэмгийлэх дайн, Манжийн түрэмгийлэлийн эсрэг бүх монголыг нэгтгэхийн төлөө дайн гэх мэтээр өрөөсгөл дүгнэн тайлбарлах болсон билээ. Энэ ч ламаизмын нэрийг цэвэр үлдээж өгөх нэг шалтгаан болсон бололтой. Ингээд одоо би монгол ба төвөд нутагт болж өнгөрсөн ариун дайнуудын түүхийг товч үзүүлэхийг оролдъя.

Төвөдийн буддизм: Улаан Шар хоёр

Төвөдийн буддизмийн түүх Христос тооллын 6-р зууны сүүл хагасаас эхэлнэ. 15-р зуунд агуу их сэтгэгч Зунхав (Цонкапа) шашны шинэтгэл хийж шинэ урсгал гаргасныг монголчууд “шар малгайтны буюу Шарын шашин”(лам нь гэрлэж болохгүй), уламжлалт хуучин урсгалуудыг “улаан малгайтны буюу Улааны шашин”(лам нь гэрлэж болно) гэнэ. 15-17 дугаар зуун бол бүхэлдээ энэ хоёр урсгалын засгийн эрх ба нэр алдар булаалдсан урт хугацааны шаргуу тэмцлийн түүх байлаа. 14-р зууны дунд үеэс засгийн эрхэнд гарч Төвөдийг шашны эрхэт (теократ) улс болгосон Улааныхан¹⁶, жил ирэх тутам өргөжин дэлгэрч байсан Шарын шашныг өөрийн заналт дайснаар үзэж, үе үе цэргийн хүчээр дарангуйлж, Шарын хийдүүдийг Улааны хийд болгож байв.

Шарынхан өөрийгөө хамгаалъя гэвэл Төвөдийн засгийн эрхийг авах хэрэгтэй, аврагч цэргийн хүчинтэй байх хэрэгтэй байлаа. *Үүнийг зөвхөн гадаадын хүчирхэг улсын тусламжаар хийж болно. Тэд, Хубилай хааны үеийн хүчит, баян Монголын ивээлийг мөрөөдөж байлаа. Гэтэл одоогийн Монголын хаад Улааны шашинтан байдаг!? Дайнч монгол хаадыг л Шарын шашинд оруулчих хэрэгтэй. Ингээд л болох нь тэр!*

Шарын шашны гол төв болсон Лхаса хотын Бригүн хийд энэ ноцтой ажлыг санаачилсан билээ. Бригүн хийдийн ширээт лам Содномжамцын итгэлт нөхөр Зогэ А-сэн лам, Монголын Түмэд газрын Алтан хааны ордонд яаралтай очлоо(1571). Тэр лам, Бригүн хийдийн ширээт ламтаныг Алтан хаан өөрийн улсад урих адистидтэй цаг ирснийг түүнд битүү ойлгуулж чадлаа. Битүү гэдгийн учир бол тэр үеийн монгол хаад Улааны шашинтай буюу түүнд талтай байсанд оршино.

Алтан хаан удалгүй Содномжамц ламтанд урилга явуулав. Ламтан, Ламын шашны урсгалуудын түүх, ёс суртал, хоёр үндэстний түүх, улс төрийн байдал, сэтгэлгээний аргыг сайтар мэдэх эрдэмтэн лам нарын (төвөдийн талаас Зундуйсамбуу, монголын талаас Хутагтай сэцэн) бүрэлдэхүүнтэй тусгай төлөөлөгчдийг удаа дараа харилцан солилцож хэдэн жил нухацтай бэлтгэл хангасны дараа (1578) ирсэн. Хаан лам хоёр, бие биеийн эрх ашиг, аюулгүй байдлыг харилцан хамгаалах тухай хэлэлцээр хийж хаан ламд Далай лам, лам хаанд Номын хаан (Dharmaraja-Буддийн шашны эзэн) хэмээх цол олгов.

¹⁶ Төвөдийн ламаизмын Гармапа салбарын нэгэн хутагтад (14 зуун) Монголын хаан алтан эмжээртэй улаан малгай бэлэглэснээс хойш тэднийг Улаан малгайтан гэх болсон нь цаашид Шарын (Зонховын) шашны сөрөг урсгалуудын ерөнхий нэрлэлт болжээ.

Энэ үед Халх монголын (одоогийн Монгол улсын нутаг) эзэн Автай сайн хан хээр гөрөөлж явтал морины нь хөл доор газар "бур" хийсэн чимээ гарган цөмөрч "хан" хийсэн төмөрлөгийн чимээ соностов. Ухаад үзтэл алтадсан гуулин бурхан гарав. Энэ хүн дүрстэй эд юу гээч юм бол? гээд мэргэн хүнийг дуудаж асуутал: "Аа энэ бурхан"¹⁷ гэдэг юм байна. Хаантан та Бурханы шавь болохын бэлгэ тэмдэг байна" гэв.¹⁸

Ингээд Автай сайн хан, өмнөд монголд заларч байсан Далай Ламд бараалхаж Очир номын хаан (Vajra-dharmaraja) цол аваад ирэх нь тэр (1585). Монголчууд нэр цолд дуртай байлаа. Тэдэнд нэр цол өгөөд л байвал шарынхны санасан хэрэг тэгш мөсөн дээр тэргийг түлхэх мэт хялбар бүтэж байв¹⁹. Монголд төвөд лам багш нарын үер бууж, монгол шавь нартаа төвөд номыг цээжлүүлж, Шарын шашны сүм хийд борооны дараах мөөг мэт ургав.

Далай лам Содномжамц, Монгол оронд олон удаа айлчилж Төвөд ба Монголд Шарын шашин ноёрхох бат суурийг тавиад бурхан боллоо (1588). Түүний гэгээн сүнс Монголд, тэгэхдээ бүүр Чингис хааны удамд Алтан хааны ач хүү болон төрснийг (1589) 1Ү Далай Лам болгон Лхаса хотод хүргэв(1604).

Нэгдүгээр шамбалын дайн

Нүдний өмнө болж буй эл бүхий явдалд дургүйцэл нь туйлдаа хүрсэн төвөдийн Улааны Зан мужийн хан Пунцагнамжил Лхасыг байлдахаар цэрэг хөдөлгөв. Одоо монголчууд шинэ монгол Далай Лам, Шарын шашнаа аврах шамбалын ариун дайнд мордоцгоолоо. Ариун дайны анхны шонхор нь мэдээж, Түмэдийн Алтан хаан ба Халхын Автай сайн хааны ноёд байлгүй яахав. Хөх нуурын Түмэд монголын ноён Лувсанданзанжамц, Сэцэн хунтайж Гүр хоёрын удирдсан монгол цэрэг, Пунцагнамжилын цэргийг цохин ухрааж өглөө. Дараахан нь Халх монголын эзэн Түмэнхэн сайн ноён, жанжин Ахай дайчин хоёрын удирдсан их цэрэг Лхасад ороход хөөрхий монгол Далай Лам нэгэнт бурхан болчихсон байжээ(1616). Хорин долоохон настай тэр лам өөрийн үхлээр үхээгүй нь мэдээжийн хэрэг. Шарын шашины дэд тэргүүн Банчен богд=Панчен Лама²⁰, Түмэнхэн сайн ноёнд Номын хаан цол, мөнгөн тамгыг шууд олгож аргадлаа.

Пунцагнамжил хүчээ сэлбэсний дараа Лхасыг байлдан эзэлж шарын хийдүүдийг улаан болгон хувиргалаа (1618). Гэвч авралын од-монгол цэрэг даруй Лхасад ирж Улааны цэргийг ихэд хядаж туслав. Шинээр тодруулсан тавдугаар Далай Ламын дэргэд монгол генералууд цэргийнхээ хамт ээлжлэн сууж хамгаалах боллоо. Арван гурван настай байсан залуу Далай Ламын номын багшаар халх монголын номч лам Лувсанбалжирыг томиллоо. Дөрөвдүгээр Далай лам нэгэнт их Чингис хааны удамд

¹⁷ бурхан – монгол хэлээр будда гэсэн үг.

¹⁸ Энэ бол хожим гарсан сайхан монгол домог. Автай буддизмыг мэдэхгүй байсан биш,улаан ламаизмд талтай байсан нь бусад домогоос мэдэгддэг.

¹⁹ Олон монгол ноёд, лам нарт санскрит, төвөд, монгол хэлээр янз бүрийн цол өгснөөр барахгүй өндөр албан тушаалаар шагнасан тухай Д.Дашбадрах, *Монгол-Түвэдийн улс төр, шашны харилцааны түүх*, УБ, 1998, 33-34-р талд үзэж болно.

²⁰ Дашлхүнбэ хийдийн ширээт ламтанд Баруун монголын Гүүш хаан, Банчен богд цол олгож (1635) Төвөдийн ерөнхийлөгчийн зэрэгтэй тушаалд тавьсан. Хожим Манжийн хаан түүнд Банчен-эрдэни гэдэг монгол цол олгосон юм (1713).

төрсөн болохоор дараахи Далай лам нарыг Чингис хааны “цустай” гэх дайнч үзэл суртал шарын шашинд зохих байраа эзэлсэн билээ.

Нэгдүгээр шамбалын дайны үр дүн: шарын шашин, ялангуяа Далай лам монгол цэргийн хамгаалалтад орж чадлаа.

Шарынхан монгол Дармарааж нар буюу шашны Сахиуснуудыг төрүүлж тэдний мэсийн хамгаалалд орсон нь Улааныханы атаархал, хорслыг бадраав. Төвөдийн Зан. Бэри хоёр газрын ноёд Шарын эсрэг холбоо байгуулж чадсан боловч хүч нь мөхөсдөж байлаа. Тэд бас монгол Дармараажийн мэсийг хүслээ. Хубилай хааны үеэс уламжлалт монголын улаан шашны гэгээрүүлэгч хаан Лигдэн, хаан хүү Цогт тайж нарын тусламжид тэд бат итгэж байв.

Монголын Буддизм

Чингис хааны хүү Өгөөдэйг их хаан байх үеэс монголын ноёд, ламын шашинд орж Төвөдийн алдартай лам нарыг ордондоо урьж олон жилээр багшлуулах уламжлал тогтсон байлаа. 1247 онд анхны төвд лам ирснээс эхлэн 1368 он (Юан улсын мөхөл) хүртэл олон төвөд лам монгол хааны дэргэд “улсын багшаар” сууж байв. Тэд хааны ивээлд он удаан эрх дураараа байсан нь сүүлдээ хэрээс хэтэрч муухай нүгэл үйлдэх болсон нь монголчуудыг Хятадаас хөөн гаргах бослогод нэгдэхийн нэг шалтгаан болсон юм. Түүхийн тэмдэглэлээс: “хуврагууд журамгүй явдал үйлдэж айл бэр буулгах ба охин мордуулахад “дээж авах” (*онгон хальсыг хагалах*) хэмээн самуун явдал үйлдэж хууль бусаар аашлах болсонд хятад улс нэлэнхүй сэтгэл урван эвсэлдэж илүү 8 сарын 15-ны сар ургах цагт хуврагуудын толгойг огтолж сар тахив... Тогоонтөмөр хаан ламд (Гунгаалодой) хилэгнэж “лам чи өөрийн орондоо ангижрагтун” хэмээсэнд лам... Сажийн²¹ зүгт эргэв.”²²

Ингээд монголын ламаизмын буурлын үе 200 жил үргэлжилсний дараа дахин сэргэж төвөдөөс лам багш нарыг дахин залах цаг болоход төвөдийн ламаизм дотроо хагараад Улаан, Шараараа цус урсган тэмцэлдэх болчихсон байв. Улаан Шарын эсрэгцэл монголчуудын дунд нэгэн адил хүчтэй өрнөв. Монгол ноёдын нэг хэсэг нь тэр Шарын шашин гэгч нь эмс охидоос “дээж авах” (*дефлораци хийх*) мэтийн нүгэлийн эсрэг үзэл сурталтай болохоор түүнийг даган хошуурч байхад нөгөө хэсэг нь Богд Чингис хаанаас соёрхолтой²³ хуучин Улаан шашнаа хамгаалах талд бат зогсч байлаа. Шарынхан нь Улааныхныгаа тэрсүүдэд тооцож, Улааныхан нь Шарынхныгаа тэрсүүдэд тооцож харилцан шамбалын дайнд бэлтгэж эхэллээ.

Хоёрдугаар шамбалын дайн

Төвөдийн Улааныхан, Монголын их хаан Лигдэн, хаан хүү Цогт нарт нууц элч илгээж цэргийн тусламж гуйв. Тэд тэр гуйлтыг хүлээж байлаа. Тэр үед Банчен-эрдэни,

²¹ Саж – Төвөдийн улаан ламаизмын алдарт Sakya хийдний монгол нэр

²² Д.Цэрэнсодном, *Монголын бурхан шашны уран зохиол*, УБ., 1997, 98-99-р тал.

²³ “Чингис хаан, Сажа Бандидатай жинхэнэ учраагүй боловч холоос лам барьж Төвөдийн бүх хуврагийг албанаас гаргаж олон хийдүүдэд өргөл хүндлэл үйлдэж шашны их өглөгийн эзэн болсон, Төвөдөөс бурхан шүтээнийг их залж бишрэн тахих зэргээр тэр үед Монгол оронд шашны эхийг олсон” (Дармадалаа, *Монгол оронд ламын шашин дэлгэрсэн түүх-Цагаан лянхуан эрхис*, УБ., 1995, тал 43). Ийм учраар монголчууд түүнийг Богд Чингис хаан гэж нэрлэн тахиж ирсэн юм.

Далай лам нарын баруун гарын шавь баруун монгол-Нэйж тойн хутагт багшийн номлолыг хүртсэн өвөр монголын бараг бүх ноёд Шарын шашиныг дагаж, багшийнхаа зааврын дагуу, Мүгдэн хотноо байсан Монголын төрийн шүтээн-Махакала бурханыг (Image of Budda Mahākāla he is the special protector “Lord” of Mongolia) Манж улсын эзэн хаанд өргөж дагаар орсон байв. Лигдэн хаан тэдний эсрэг цэрэглэн орсон боловч Манж цэрэгт дийлдээд ухарч байсан цаг байлаа(1634).

Лигдэн Цогт хоёр яагаад Шарын шашны эсрэг нэгдэв? гэдэг бол зангилаа асуудал юм. Тэр хоёр бол ердийн нэг сүсэгтэн биш, монголын ламын шашны соён гэгээрүүлэгчид байсан болохоор шамбалын дайны домгийг бод болгон ашиглажээ. Тэд уламжлалт (улааны) ламаизмыг Чингис хааны адистидтай, монголын үндэсний шашин болсон гэж үзэж, түүнийг улам хөгжүүлэх, ном судруудыг монгол хэлээр орчуулах, сүм хийдийн уншлага мөргөлийг монгол хэлээр явуулах ажлыг өргөтгөх, чингэснээр ламын шашныг сүсэгтэнтэй нь жинхэнэ ёсоор холбож өгөх үндэсний соёлын бодлогоор холбогдож байлаа. Лигдэн, буддизмийн их нэвтэрхий толь-108 их боть Ганжуурын орчуулгыг зохион байгуулж, монголын шашны төв болсон олон сүм хийд байгуулснаар “Лигдэн хутагт, Суут чингис цэцэн, Зүгүүдийг ялгагч (зүгийг заагч), Тэнгэрийн Тэнгэр, Дэлхий дахины Хурмаст (дэлхийн бүх хүний Индра), Алтан хүрдийг орчуулагч (эргүүлэгч) номын хаан (дармаража)” хэмээн алдаршсан хүн байв. Цогт бол бас ном судруудын орчуулгыг зохион байгуулагч, олон сүм хийд, соёлын ордон байгуулагч, нэрт яруу найрагч байсан.

Шарын шашиныг цахилгаанчлан дэлгэрүүлэх явцад лам нар төвөджиж, шашны монгол уншлага хаагдаж, монгол хэл бичиг хаягдаж, улмаар шашин сүсэгтэн хоёрын хооронд үл ойлгогдох харь төвөд хэлний хана хэрэм босч байгааг тэд тэвчиж чадахгүй байлаа. Хэргийн чухам учир юунд оршиж байгааг тэд сайн мэдэж байлаа. Тэр бол Шарын шашиныг ямар үнээр хамаагүй дэлгэрүүлэх гэсэн Далай ламын аюулт бодлогыг таньсан хэрэг юм. Тийм ч учраас Цогт тайж, хэргийн гол үндэс болсон Далай лам, далай ламчлалыг устгахыг тэргүүн зорилтоо болгож 20 000 цэрэг авч Лигдэнгийн цэрэгтэй нийлэхээр Төвөдийн зүг гарч Хөхнуурын газрыг ²⁴ эзлэв(1634).

Лигдэнгийн цэрэг Хөхнуурын зүг явах замд цэцэг өвчний аюулт тахалд нэрвэгдэж бүрэн сүйрэв гэж түүхийн сурвалжид дурджээ. Энэ ч монгол Далай ламын гэнэтийн үхлийн адил зуурдын хорлол болсон буй заа. Энэ тухай “тэрслэгч этгээд Лигдэн хаан, шарын шашны сахиусны хүчээр Шар талд үхэв” гэжээ. ²⁵

²⁴ Морин цэрэг Хималайд нэвтрэх дөт замын үүд, одоогийн Хятадын Цинхай муж.

²⁵ Ж.Дашдондог, *Халхын Цогт хунтайж*, УБ., 1992, тал 11.

Мо.Сахиус (төвөд. Srung-ma, санскр. Pāla) гэдэг нэр томьёог Genius protector, Guardian angel, Lord, tutelary gods of religion, хамгаалах нууц хүч гэх мэтээр орчуулан ойлгож болно. Энэ үг, ламын шашинтны сэтгэлгээнд Бурхан/Тэнгэр (Budda, god, deity) гэдэг үгтэй синоним хэрэглэгдэнэ. Олон сахиусны дотроос бурхны шашин, түүний орон, сүсэгтэн нарыг сахин хамгаалах үүргийг өөртөө үүрч авсан домогт сахиуснуудын магтаалыг хурах (лам нарын хоороор аялгуулан унших), тэднийг тахиж явдал бол ламын шашны сүм хийд ба лам нарын өдөр тутмын пратикт гол үйлдэл байдаг. Тэднийг Арван догшид (10 redoubtable gods) гэнэ. Тэдний хөрөг зургийг үзвэл үнэхээр догшин бодгалийн (individual) сүр хүчин төгс бөгөөд нэн аюумшигтай. Араа соёо нь арзайсан олон толгой, олон гар хөлтэйгөөр барахгүй, цус дуслуулсан нойтон хүний толгойнуудыг хэлхэн хүзүүндээ сондор болгосон, хохимой ясан толгойнуудыг хэлхэн титэмлэсэн, үс сахлаас нь гал

Төвөд Монголын улаан эвслийг хоёр улсын хаад зохион байгуулж ихээхэн цэргийн хүч хуримтлуулж байхад Далай лам өөрийн “сахиусгүй” (армигүй) байлаа. Тэр, хуучин улааны уламжлал бараг үгүй шинэхэн шарын шашинт баруун монголын хаад ноёдод нууц элч илгээлээ. Баруун монголын хаан Байбагас, өөрийнхөө дүү Төрбайх ноёныг төвөдөд нууцаар очуулж (1625) IV Банчен-эрдэнитэй нууц хэлэлцээр байгуулан ойрын ирээдүйд болох дайны бэлтгэлийг хичээнгүйлж эхлэв. Төвөдийн улс төр, ялангуяа газар нутгийг судлуулах, Цогт тайжийн ажиллагааг тагнуулах, хорлон сүйтгэх ажлыг зохион байгуулахаар Төрбайх тэргүүтэй арван сайн эрийг мөргөлчдийн дүрээр Төвөдөд явуулав (1635).

Энэ үед Хөхнуурт хаан болоод байсан Цогт, өөрийн хүү Арсланд түмэн цэрэг өгч Далай ламыг устгуулахаар довтолгов. Мөргөлчний дүрээр тэнд тагнуул хийж явж байсан Төрбайх, залуу Арсланг тосч уулзаад шарын шашинд хорлол учруулж болохгүйг ятгаж чадсанаар барахгүй, түүнийг Далай ламд мөргүүлж, өөрийн нь холбоотон төвөдийн улааны цэрэгтэй байлдахад хүргэж чадав гэх.

Ингээд удалгүй Төрбайхын удирдсан Баруун монголын үлэмж их цэрэг Хөхнуурын газрыг довтолж Цогт тайжийг цохив (1536). Энэ тухай түүхийн сурвалжид Гүүш²⁶⁾ хааны ганц түмэн цэрэг, Цогтын дөрвөн түмэн цэргийг ганц өдрийн дотор дуустал хядав гэж бахархан дурдсан байдаг.

Гүүш хаан цааш хэдэн жил төвөдийн улаан шашны цэрэгтэй дайтан ялалтыг олж Далай лам, Банчен-эрдэни хоёрыг Төвөдийн ламын шашны тэргүүн болгож (1642), өөрөө Төвөдийн хаан болсон билээ. Энэ тухай төвөд сурвалжид “хоосон огторгуйг хос нараар чимсэн мэт” гэж магтан дуулжээ.

Энэ дайн бол Монголын Гүүш хаан Төвөдийг эзэлж авсан дайн биш, түүнд тийм санаа ч байсангүй, зөвхөн Шарын шашин, Далай ламыг Төвөдийн засагийн эрхэнд гаргах зорилготой, тэдний хүсэлтийн дагуу хийсэн шамбалын дайн л байсан. Тийм ч учраас Далай лам Гүүш хаанд Төвөдийн засагийг бэлэглэсэн юм. Учир нь Гүүш хаан бол дармаража буюу шарын шашны сахиус болчихсон байв.

Тухайн улсын эзэн хаан, төрийг төдийгүй шашныг нар мэт ивээсэн дармаража мөн байвал түүний улсыг хос ёст улс гэж нэн эрхэмлэх суртал буддизмд эртний уламжлал байв. Бага буурай улс өөрийн хүсэлтээр дармаража хааны улсад нэгдэн

дөрөлзсөн, гартаан элдэв янзын мэс зэвсэг барьсан бодгалис харагдана. Нэн бас амандаа хүний үхдэл тас зууж санжигнуулсан, хүний гавал ясан аяганд бургилан буй хүмүүний цусыг уун завдсан, өөрийн Шагти хэмээх янагтайгаа хурьцал үйлдэлдэн буй зэргийн аймаар, хачирхмаар, залбирмаар дүр зураг нүдэнд тусна. Бурхны шашны домгийг үндэс болгон хэлбэл тэдгээрийн зарим нь эрт нэг цагт бурхны шашныг эсэргүүцэн байлдаж яваад дийлдэж ялагдалаа хүлээн бурханы шашинд дагаар орж цаашид бурхны шашны сахиус болж явахаар Бурханы өмнө андгайлсан, зарим нь Тэнгэр бодисадва нар бурханы шашны дайсан-тэдгээр аймшигт бодгалисын дүрээр хувилан тэдэнтэй байлдаж номхотгож өгсөн зэргийн түүх намтар бүхий догшин дүрт Бурхад ажээ.

Хэрэв Буддизм гэдэг үгийг цуст дайн гэдэг үгтэй холбон хэрэглэвэл байж болшгүй ойлголт болно. Харин тэр цуст дайн гэдэгийг сахиусны хүч, сахиусны дайн, сахиусны хорлол гэж соливол ердийн, хэвийн ламаист ойлголт болно. Тэгэхлээр Шарын шашныг хамгаалсан монголын армийн ажиллагаа бол шашны сахиусны буюу шамбалын цэргийн хийсэн ажил болох юм.

²⁶⁾ Гүүш/гүшри хаан (номын/шашны хаан = Дармараджа)- Төрбайхад Далай ламын өгсөн цол

орохыг монгол хэлээр “дагаар орох” (*хүсэлтээрээ протекторат болох*) гэнэ. Тэгэхлээр Далай лам, Гүүш хаанд дагаар орсон хэрэг юм. Дагаар орохоос өөр аргагүй байв. Тэр үед Төвөдийн засагийн эрхэнд байсан Улааны аллагын аюулаас айсан Далай лам, Банчен-эрдэни нар Төвөдөөс гарч Гүүш хааны ивээлд багтахаар Хөх нуурын орчим нүүж ирээд байсан цаг юм. Зарим түүхч энэ явдлыг Төвөд улс Монголын колони болсон гэж бичсэн нь бий. Дагаар орох, колони болох хоёр бол яг адил зүйл биш болно. Монгол хаанчлал Төвөдөд 70 жил үргэлжлэв. Гүүш хаан нэгэнт дармаража болохоор Лхаса хотын Будалан хэмээх жижиг уулыг өвч бүрсэн олон давхар сүрлэг ордонг Далай ламд зориулан байгуулах олон жилийн нүсэр ажлыг өрнүүлэх, Улааны лам нарын эсэргүү бослогыг цус урсган дарах (1642) зэргээр Шарын шашныг ихэд тэтгэсэн билээ. Тэр, цаашид Далай ламын хүсэлтийн дагуу ламын шашинт бусад улст (Бутанд 1644, Ладагт 1681) шамбалын дайны ажиллагаа явуулсан юм.

Хоёрдугаар шамбалын дайны үр дүн: монгол дармаража, төвөдийн улаан тэрсүүдийг дахин өндийхгүй болтол бут цохиж Төвөдийг шарын шашны теократ улс болгож өглөө.

Гуравдугаар шамбалын дайн

Далай лам Төвөдийн ламын шашны эзэн болж, Банчен-эрдэни Төвөдийн ерөнхийлөгчийн чанартай эзэн болж монгол цэрэгтэй төдийгүй өөрийн төвөд цэрэгтэй болсон болохоор төвөдийн улаан тэрсүүдийн аюулаас айлтгүй боллоо. Гэвч Монголын улаан тэрсүүд хэзээ нэгэн цагт Гүүш хаан мэт гэнэт дайран ирэх аюул оршиж байв. Лигдэн, Цогт хоёроос илүү аюул учруулах тэрсүүд бол Монголын ламын шашны тэргүүн Өндөр гэгээн Занабазар (1635-1723) байлаа. Банчен-эрдэни, Далай лам нар түүнийг 4 настайд нь аргагүйн эрхээр (улааны шашинт монгол төвөд хаадын санааг шууд эсэргүүцэж гелүгпагийн хутагт болгож болохгүй байсан) төвөдийн улааны шашны эрдэмтэн лам Дарнатын хувилгаан гэж баталж өгөөд цаашдын замд нь сурган хүмүүжүүлэх аргаар шарын шашны хамгаалагч болгож болно гэж итгэж олон талын ил далд ажиллагаа явуулсан юм.

Гэтэл тэр тэгсэнгүй, ламаизмын урсгалуудын талаар Чингис хаанаас уламжлалтай хүлээцтэй хандах (толерантность) бодлого явуулж байлаа. Тэрвээр ердийн нэг лам биш, Монголын хаан хүү, монголын улс төрийн бодлоготон байсан болохоор Лигдэн Цогт нарын улаан шамбалын дайн, Гүүш хааны шар шамбалын дайны учир утга, Далай ламын эрээгүй бодлогыг нэвт мэдэж байсан боловч шарын шашныг сектийн нь хувьд хүндэтгэж, ламаизмын улаан шар хоёр салбарыг адил тэгшээр үзэж байсан болохоор Төвөдийн шар хутагтыг (Далай лам) Монголын улаан хутагтаас (Богд Жебзундамба ²⁷ дээгүүр тавьж болохгүй байлаа. Түүний толерант бодлого өөрийг нь “Зонховын тавцан ба, Далай ламын сургаалыг доромжилсон” ²⁸ гэмт хэрэгтэн болгочихсон билээ.

Далай ламын засагийн газар Шарын шашны дайсан-Халхын Түшээт хан ба Жебзундамба хутагтыг дарах шар шамбалын дайны армийн генералаар тэр үед Зүүнгар

²⁷ Жебзунд~~аран~~атын хувилгаан гэгдсэн Занабазарт 10 насны нь ойгоор Далай лам, Жебзундамба хутагт гэсэн цол шагнасан нь түүний улаан өнгө сацруулаад байгаа алдар нэрийг шарлуулах гэсэн санаа бололтой.

²⁸ Далай ламын засагийн газараас Манжийн хаанд явуулсан захидал. Д.Дашбадрах, Монгол-Түвэдийн улс төр, шашны харилцааны түүх. Уб., 1998, тал 82.

(Жунгарское ханство) гэж нэрлэгдэж байсан баруун монголын хаан Галданг сонгон авлаа. Тэрвээр Далай ламын дэргэд 20 шахам жил ламын эрдэмд суралцаж түүнээс “Бошигт” цолыг авсан, шарын шашны төлөө улайран тэмцэгч байлаа. Далай ламын засагийн газар ба Галдан, дайн эхлэх шалтаг эрж эхлэв. 1686 онд Монголд болсон халхын ноёдын хоорондын тэмцлийг эвлэрүүлэх чуулганд оролцсон Далай ламын төлөөлөгчийг хүндэлсэнгүй гэдэг дайны шалтаг оллоо: Түүхийн сурвалжид бичсэнээр уг чуулганы танхимд Жебзундамба хутагтыг Далай ламын элчээс өндөр суудалд суулгасанд тэд дургүйцэл илэрхийлэв гэх. Суудлын тухайт энэ явдал бол чухамдаа улааны шашныг шарын шашнаас дээр тавьж Далай ламыг илтэд доромжилсон хэрэг болчихжээ.

Ингээд Галдан бошигтын 30 000 их цэрэг Халхыг довтолж (1688) улаан тэрсүүдийн сүм хийдүүдийг үнсээр хийсгэж, улаан лам нарыг цусан далайд умбуулав. Ялагдал хүлээсэн Жебзундамба хутагт, төв монголын долоон хошуу Халхын 40 000 хүнийг дагуулан өмнөш дүрвэж Манжийн хаанд дагаар оров. Галдан бошигт араас нь нэхэж Хэрлэн гол хүртэлх замд зүүн монголын улаан сүм хийдүүд сүйрч 100 000 өрх (айл)²⁹ Манж улсад, олон арван мянган нүүдэлчид умар зүг дүрвэн гарч Орос улсад дагаар орсон билээ. Дагаар орсон Халхыг хамгаалан Манж хаан, Галданыг дарах их цэрэг (тоо 115 170) өөрийн биеэр авч одсон ба юу болсныг тайлбарлалтгүй биз.

Ийнхүү гуравдугаар шамбалын дайны үр дүн: Монголд улааны тэрсүүдийн аюул сөнөж, бүх монгол нутагт шарын шашин ноёрхов. Манж улсын хаан Шарын шашныг дэмжих бодлого барих болж, Жебзундамба хутагтыг монгол хүн болж төрөх явдлыг зогсоож Төвдөд хувилан төрдөг болгов.

Монголын түүхийг судлагчид Галдан бошигтын дайны учрыг ламын шашинтай холбохгүйгээр, түүнийг бүх монголыг нэгтгэн хаан нь болж, Манжийн түрэмгийлэлээс Монголыг аврах зорилготой дайн байсан мэтээр одоо хүртэл тайлбарласаар байна. Гэтэл үнэндээ Галдан шарын шашныг л бодож байснаас биш, тэр тухай бодоогүй юм. Галдангийн генерал Данжила уг дайны эцэст түүнээс салж одохдоо түүнд хэлсэн эцсийн үг: “Чи ямагт Зонхубын шашны тулд явмуй гэсээр Дөрвөн Өөлд (Дөрвөн Ойрд буюу баруун монгол), Долоон хошууны Халхыг дуусгав. Чиний улс эвдрээд, эцэг хөвгүүн, эр эм салав”.³⁰ Тэр үнэнийг хэлжээ. Галдан, Санзайжамц (Далай ламын засагийн газарын ерөнхий сайд) нар Манжийн хаанд ноот бичиг явуулж хүссэн юм нь Түшээт хан, Жебзундамба хоёрыг л амьдаар нь өөртөө тушаахыг гуйж байсан.

Хэрэв Галдан, түүхч нарын бичдэг шиг манжийг эсэргүүцэх зорилготой байсан бол төв ба зүүн монголын ламын шашны сүм хийдүүдийг шатааж³¹ лам нарыг алан хядах учир үгүйсэн билээ.

Галдангийн их цэрэг бүрэн сүйрч улсаа алдаад үхэл ойртоход тэр бас эцсийн үгээ хэлсэн юм: “Миний энэ Хэрлэний газар ирсэн нь миний санааны дураар гүн орж

²⁹ Энэ тоог “Ардын эрх” сонины 1995, дугаар 142 үз.

³⁰ Ил Товчоо.Уб., 1998, № 16.

³¹ “Санамсаргүй байтал Өөлд ирж миний сүмүүдэд гал тавиад эвдэж дуусгав... Бид цөм дагаж орсугай” (Жебзундамбаас манж хаанд бичсэн захидалын үг, Ил товчоо,Уб.,1998, дугаар 16, тал 6).

ирсэн бус, Далай ламын зарлигаар намайг урагш орж явбаас маш сайн, их баяр байна хэмээснээр би гүн орж ирж явав. Далай лам намайг алав”.³²

Галдан, “Улаантаны үүр” болж байсан Жебзундамбын гол хийдүүд-төв халхын Шанхын Баруун Хүрээ, Хөгнөханы хийдүүдийг устгасны дараа зүүн зүг рүү олон зуун км хол явж Хэрлэн гол хүрсэнд ноцтой шалтгаан бий юм: Жебзундамбын байгуулсан³³ бас нэг улаан хийд “Хэрлэний Зүүн Хүрээг” устгах ёстой байжээ.

Шамбалын дайны эш бошиг үзүүлэгчид (prophets)

Ирээдүйд шамбалын дайн (монг. *šambal-un dayin*) болно гэсэн эш (prophecy) нь Калачакра судар, түүнийг номлогч нь Бурхан багш гэж итгэх тул ерөнхий эш бошиг үзүүлэгч нь Бурхан багш (Budda) болж очно. Тухайн цаг үеийн байдлыг шинжлэн дүгнэж шамбалын домогт улс төрийн актуализац хийж тодорхой эш үзүүлэгч нь Лам багш нар (Хувилгаан буюу Хутагт, Гэгээн буюу Ринбуучий, Их бясалгалч буюу Егүзэр, Мэргэн багштан г.м) болно. Монголчуудын явуулсан гурван шамбалын дайны эш бошиг үзүүлэгчид нь Монгол ба Төвөдийн хутагт дээд лам багш нар байсан. Үүний нэг баталгаа нь Галданы дээр дурдсан эцсийн үг юм. Бас нэг чухал мэдээлэл бол түүний Бошигт³⁴ (Galdan Bosigtu) гэдэг цолд байна. Галдан уг нь Төвөдөд 20 шахам жил суралцаж ламын шашны эрдэмд гүн боловсорч, Энса хутагтын хувилгаанаар тодорч Төвөдийн шарын шашны Гандан хийдийн хамба ламаар тохоогдоод байтал гэнэт баруун Монголын хаан ширээ эзгүйрэхэд (Шарын сахиусны хүч биз) Далай лам түүний шарыг тайлж (сахилыг хурааж) түүнд бошиг (=зарлиг, шамбалын дайны бошиг биз) өгч хаан болгосон тул бошигт (зарлигт) цолтой болсон билээ.

Цаг үеийн эш бошиг үзүүлэгч нь тухайн орон нутгийн багш буюу мэргэн лам ч байж болно. Тэдний бошиг, тухайн үеийн нийгэмийн бүлэгийн юмуу эсвэл нэг буюу хэдэн улсын улс төрийн бодлогын үзэл суртлын үндэс буй болгоход чиглэж байсан юм. Үүнд, 19 дүгээр зууны сүүлчээр Буриад-монголын хамба лам Агван-Доржиев, 13 дугаар Далай ламад Шамбалын орон бол Хаант Орос улс мөн, Оросын хаан бол Шамбалын хаан мөн гэж итгүүлэхийг оролдож байсан, Халимагийн лам Дамбо Ульянов Шамбалын орны нийслэл Калава хот гэдэг бол Москва мөн, Оросын хааны Романов удамынхан бол Буддагийн удамтай холбоотой гэж итгүүлэхийг оролдож байсан³⁵, өнгөрсөн зууны эхээр зүүн монгол ба Буриадад панмонголизмын үзэл санаа дэгдэхэд шамбалын цэрэг Японоос ирнэ гэж, дөчөөд онд гитлерийн арми Москвад ойртоход шамбалын цэрэг сонгодог зүгээсээ (баруун) ирж байна гэж лам багш нар бошиг үзүүлж байсан тухай баримт бий юм.³⁶

³² Дашбадрах Д., дурдсан зохиол, тал 83

³³ *Монголын нэвтэрхий толь*, I-боть, 604 тал хуудас, тал 405.

³⁴ Үгчилбэл зарлиг бүхий, санаа нь prophecy бүхий хаан.

³⁵ Karénina Kollmar-Paulenz. *Utopian Thought in Tibetan Buddhism: A Survey of the S'ambhala Concept and its Sources*. Studies in Central and East Asian Religions, 1992-93, vol. 5-6, p. 86-87.

³⁶ Luboš Bilka, дурдсан зохиол, тал 21.

Shambhala and the Shambhala war

When the Mongols – natural people with mythological thinking – came across an important text of Vajrayana – the „Paramadibuddhoddhita śrī Kālačakra nama tantraraja“, the myth of Shambhala and the Shambhala war settled deeply in their thoughts. This resulted into the Shambhala – complex“ of the Mongolian people. In fact it means that they took for their ideal to fight in a Holy war for the sake of their Buddhist religion. Following its call the Mongols several times fought bloody Shambhala wars among themselves.

The First Shambhala war: The patron of the Red sect, the Tibetan king Puntsognamjil, initiated the war against the Yellow sect, which was rapidly gaining power in Tibet. But in that time, suddenly, the young Mongol Dalai lama - head of the Yellow sect – died (1616, of course his death was not natural). Punsognamjil occupied Lhasa and changed the Yellow monasteries to Red. The Mongols launched a Holy war to save the Yellow religion and the Dalai-lama. Two great armies – one lead by the Tumed noble Luvsandanzanjamts and the Sechen hongtaiji Гьр, the other lead by the khan of Khalkha Тьменхен sain noyan and the general Ahaï daichin. Entered Lhasa and delivered an important help in defeating the Red army. From that time on there was allways a guard of mongol generals with their troops at the palace to protect the newly found Dalai-lama. Since the Fourth Dalai-lama was a Mongol, there arose a militant idea that the Dalai-lamas have the „blood“ of Chinggis-khagan. This idea soon found its proper place in the Gelugpa teaching.

The result of the First Shambhala war: The Yellow sect, and above all the Dalai-lama, was able to secure the protection of the Mongol army for themselves.

The Second Shambhala war: The Red sect of Tibet sent a secret mission to the Mongol Great Khagan Ligden and the prince Tsogt, asking for a military aid. The historical sources mention that the Ligden's army perished in Kuuke nuur through a dangerous epidemic of measles. The text says that the „Heretic Lidgen died on the Yellow plain through the help of the tutelar gods of the Yellow religion.“ Soon after that the enormous army of the Western Mongolian Guush han came to the Kuuke nuur region and defeated Tsogt taiji (1536). The historical source says proudly: „The ten thousand soldiers of Guush han annihilated the forty thousand soldiers of Tsogt taiji in one day.“

The result of the second Shambhala war: The Mongol Dharmaraja destroyed definitely the Tibetan Red heretics and established the Tibetan theocratic realm of the Yellow faith.

The Third Shambhala war: The highest Tibetan leaders did not like the tolerant way in which the head of the Mongolian lamaist church, the 1st Jebtsundamba (Индур геgegen) treated equally the Red and Yellow sects of lamaism. Following their command the Western Mongolian han Galdan boshigt assaulted Khalkha with an army of 30 000, „let the ashes of the Red temples blow in the wind and drowned their lamas in the sea of blood.“ The Holy Jebtsundamba with 40 000 believers fled to the south and submitted to the Manchu Emperor. Galdan Boshigt persuaded him and before he reached the river Herlen, he brought the Mongolian Red faith to ruin, made 100 000 families submit to the Manchus and many tens of thousands of nomads flee to the North and seek the protection of the Russian Empire.

The result of the Third Shambhala war: The danger of the Red heretics was sonoj and the Yellow faith flourished throughout the whole Mongolia.

The psychological complex of Shambhala was dominant throughout the history and well to the 20th century there were cases of political prophecies using the Shambhala myth concerning the wars and political events that were happening in the Mongol areas.